



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2015 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 87

Мандалговь

Хөрөнгө данснаас хасах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1. Дэрэн сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2,058,000 /хоёр сая тавин найман мянга/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй хуучин эмнэлгийн барилгыг актлан устгахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу устган, данс бүртгэлээс хасч, ашиглагдаж болох эд зүйлсийг үнэлэн эргэлтийн хөрөнгөнд бүртгэж авахыг Дэрэн сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Н.Хишигжаргалд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА

С.БУДЖАВ

